



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 1302

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Чингис Хаан брэнд дэд хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжих Хэнтий аймгийн танилцуулга нэвтрүүлэг хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн  
ахлагч:

Б.Нямхатан

Байгаль орчин, аялал, жуулчлалын газрын  
Ойн албаны дарга

Нарийн бичгийн  
дарга:

О.Сэдэд

Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Гишүүн:

Ц.Бат-Эрдэнэ

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого  
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Нямхатан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА